



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Аудитад цахим мэдээллийн нэгдсэн системийг ашиглах журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхийг Мэдээллийн технологийн төв (А.Уянга-Эрдэнэ), төрийн аудитын байгууллагын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Тамгын дарга (С.Цэрэнбаяр)-д даалгасугай.
- 3.Батлагдсан журмыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар (Б.Бундхорол)-т, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын нэгж, аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын удирдлагад үүрэг болгосугай.
- 4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Ц.Баярмаа)-т даалгасугай.

Д.ЗАНДАНБАТ